Төрийн албаны зөвлөлийн 2019 оны
03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

# ХЭНТИЙ АЙМГИЙН УЦУОШТ-ИЙН ЦАГ АГААРТ ЗОРИУДААР НӨЛӨӨЛӨХ ЭКСПЕДИЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ИНЖЕНЕР АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**Албан тушаалын тодорхойлолтын боловсруулсан үндэслэл:**

☐ Байгууллагын бүтэц, орон тоо шинэчлэгдсэн.

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

**Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:** "Аймаг, хотын ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрэм, бүтэц орон тооны хязгаарыг батлах тухай" ЦУОШГ-ын А/162 дугаар тушаал

**Дагаж мөрдөх огноо:** 2025.09.01

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:** 2025.08.13

**Байгууллагын нэр:** Хэнтий аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв

**Нэгжийн нэр:** Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедици

**Албан тушаалын нэр:** Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн үйлчилгээ хариуцсан инженер

**Албан тушаалын ангилал, зэрэглэл:** Төрийн үйлчилгээний мэргэжил ангилал, ТҮМ-5

**Ажлын цаг:** Өдрийн 8 цаг. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үед цаг харгалзахгүй.

**Ажлын байрны албан ёсны** Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2-р баг Тэмүүжингийн гудамж Н-13

**Хөдөлмөрийн нөхцөл:** Хэвийн. Цаг агаарт зориудаар нөлөөлж тунадас нэмэгдүүлхээр хээрийн гаралтанд ажиллах үед дунд зэргийн эрсдэлтэй ажлын нөхцөлд хамаарна.

**Онцгой нөхцөл:** Онцгой нөхцлийн үед илүү цагаар болон баяр амралт, шөнийн цагаар ажиллана.

## 1. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**Ажлын байрны зорилго:**

Цаг агаарын гамшигт үзэгдэл, ган цөлжилтийн нөлөөг бууруулах, хөрсний чийг, гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх, хүн техник хүрэх боломжгүй ой хөвчийн түймрийг унтраах, улс орны эдийн засаг, байгаль экологи, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг багасгах зорилгоор цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг удирдах,

Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн болон гамшгаас хамгаалах тухай бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт нийцүүлэн албан хаагчдыг арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэнд хяналт тавих

**Ажлын байрны зорилт:**

1. Монгол улсын хууль тогтоомж, Монгол улсын урт, богино, дунд хугацааны хөгжлийн бодлогын төлөвлөлт, Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай төрийн бодлого, төлөвлөлт, Засгийн газар, аймаг, орон нутгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах
2. Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлын төлөвлөлт, бэлтгэл бэлэн байдлыг хангаж, цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг оновчтой, зөрчилгүй удирдан зохион байгуулах
3. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоол, заавар, дүрэм, журмын биелэлтийг хангаж тайлан мэдээ, судалгаа, дүгнэлт, үндэслэлийг гаргах
4. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааны болон бусад салбаруудын ХАБЭА-г хангах хууль, дүрэм, журмын биелэлтийг хангах, дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих
5. Байгууллагын болон салбарын үйл ажиллагааны тасралтгүй ажиллагааг хангаж зохион байгуулалтын ажилд оролцох

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд: | Монгол Улсын хууль, Засгийн газар, БОАЖЯ, ЦУОШГ-аас цаг уурын мэдээлэл, үйлчилгээний ажлын талаар гарсан тогтоол, тушаал, хөтөлбөр, удирдамж, журам, дүрэм, бусад байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг судлан хэрэгжилтийг зохион байгуулна. | Гүйцэтгэл хувиар | Г, Х, Ш,Т |
| | Дэлхийн цаг уурын байгууллага /ДЦУБ/-ын зөвлөмж, Монгол улсын ус, цаг уур орчны шинжилгээний ажлын хөтөлбөрийн биелэлтийг хангах, гүйцэтгэлийг нэгтгэн үнэлэх | Хэрэгжилт, хувиар | Г, Х, Ш,Т |
| | Засаг даргын мөрийн хөтөлбөр болон аймгийн дунд ба урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд тусгагдсан ажил үүргийн | Хэрэгжилт, хувиар | Г |

| | | | |
|---|---|---|---|
| | биелэлтийг хангах | | |
| | “Байгууллагын архивын журам”, “Албан хэрэг хөтлөлтийн журам” –ын хэрэгжилтийг хангаж ажиллах | Хэрэгжилт хувиар | Г |
| | Салбарын үйл ажиллагаатай холбоотой хугацаатай бичгийн хариу өгөх, гэрээ дүгнэх, тайлан мэдээг заасан хугацаанд явуулах, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах | Хэрэгжилт, хувиар | Г, Х, Ш,Т |
| **2 дугаар зорилтын хүрээнд** | Пуужин, харвах төхөөрөмжийн засвар үзлэг үйлчилгээг тогтмол хийж, хадгалалт, тээвэрлэлтийн журмыг чанд сахин байнгын бэлэн байдлыг хангаж, пуужин түлшний нөөцийг бүрдүүлэх | Шаардлага хангасан пуужин, түлшний нөөц бүрдсэн байх | Г,Х,Ш |
| | Ажиллах бүрэлдэхүүний мэдлэг мэргэшлийг дээшлүүлэн, дадлага чадварыг эзэмшүүлэх, зэвсэг галт хэрэгсэл, пуужинтай харьцах сургалтыг зохион байгуулах | Ажиллагсадын ур чадвар, мэргэшлийн чадамж дээшилсэн байх | Г,Х,Ш |
| | Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн болон холбоо, сүлжээ, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн бэлэн байдлыг хангах | Бэлэн байдлыг хангасан байх | Г,Х,Ш |
| | Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны урсгал зардлыг төлөвлөх, шийдвэрлүүлэх | Шаардагдах зардал шийдвэрлэгдсэн байх | Г,Т,Х |
| | Галт хэрэгсэл, пуужинг харвалтанд бэлтгэх, шалгах, харвалтыг удирдах, ажлын явцыг хянах, бүртгэл тооцоог хөтлөх | Холбогдогдох дүрэм, журам, зааврын биелэлтийг хангаж ажилласан байх | Т, Г, Х, Ш |
| | Үүлэнд үйлчлэх урвалж цацах, солбилцолийг тодорхойлох, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр дүнг тооцох | Үр дүнг тухай бүр тооцож дүгнэлт гаргасан байх | Г, Х, Ш |
| | Цаг агаарт зориудаар нөлөөлөх үед агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдлыг хангах болон ажиллах үеийн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм, журмын мөрдөлтийг хангах, хянах | Зөрчил гаргаагүй байх | Т, Г, Х |
| | Захиалагч байгууллага, аж ахуй нэгжийн газарзүйн байршил, үүлний төрөл, шилжилтийн онцлогийг харгалзан, харвалт хийх, шилжин байрлах газар орныг сонгох | Зөв оновчтой төлөвлөлтийг хийж үр дүнг нэмэгдүүлсэн байна. | Г, Ш |
| | Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицүүдийг мэргэжил аргазүйн удирдлагаар хангах | 2 эксдепицийн үйл ажиллагааг удирдаж ажиллана. | Г, Х, Ш,Т, |

| | | | |
|---|---|---|---|
| | Байгууллагын дотоод журам, болон хөдөлмөрийн хууль бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллах | Зөрчил, үл тохирол гаргаагүй байх | Т, Г, Х, Ш |
| **3 дугаар зорилтын хүрээнд:** | Үүлний төрөл, түүнд үйлчлэх урвалжийн орцын норм, үүлэнд нөлөөлсөн ажлын үр дүнгийн тооцоо судалгаа, дүгнэлт хийх | Жил бүр судалгааны ажил хийгдэж хэлэлцүүлж танилцуулсан байх | Г, Х, Ш |
| | Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг тайлагнах | Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлын дүн, хувиар | Г, Ш |
| | Орон нутагт ажиллах замын маршрут, шатахуун, томилолт, сэлбэг хэрэгслийн тооцоо хийж, тайлагнах | Тухай бүр хийж танилцуулсан байх | Г, Ш,Т |
| | Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулах талаар хамтран ажиллах санал тавьсан аж ахуйн нэгж байгууллагатай хийх гэрээ хэлцлийн төсөл боловсруулах, холбогдох зардлын тооцоог гаргах | Шаардлагатай үед гүйцэтгэсэн байх | Г, Ш,Т |
| | Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны талаар нийтэд мэдээлэл өгөх, таниулах, үр дүнг мэдээлэх | Мэдээллээр бүрэн хангасан байх | Г,Т |
| **4 дүгээр зорилтын хүрээнд:** | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага төлөвлөлт, зохион байгуулалт, гамшгаас хамгаалах менежментийг байгууллагын онцлогт тохируулан төлөвлөх, биелэлтийг хангах | Төлөвлөгөөний биелэлт хувиар | Г,Ш,Х |
| | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар, зөвлөмж, арга зүйгээр хангах, зохицуулалт хийх, хяналт тавих | Ажлын байрны осол, зөрчил гаргаагүй байх | Г,Ш,Х |
| | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, гамшгаас хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулах | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрүүл орчинд ажиллах соёл, зан үйл төлөвшсөн байна | Г,Ш,Х |
| | Ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл, ажил үүргийн онцлогт тохируулан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах | Холбогдох хууль журмын биелэлт, хувиар | Г,Ш,Х |
| | Байгууллагын автомашины техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хугацаат үзлэг, үйлчилгээг тогтмол хийлгэх, хяналт тавих | Саатал зөрчил гараагүй байх | Г,Ш,Х |

| | | | |
|---|---|---|---|
| **5 дугаар зорилтын хүрэнд** | Хэлтсийн болон салбарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах | Төлөвлөгөөний биелэлт, хувиар | Г,Ш,Х |
| | Салбарын холбогдолтой хууль, тогтоол, албан бичигт хариу өгөх, биелэлтийг хангах | Тухай бүр шийдвэрлэсэн байх | Г,Ш |
| | Байгууллагын зохион байгуулалт бүхий арга хэмжээ, ажлын хэсгийг ахлах, удирдах, оролцоог хангах | Бүрэн оролцсон байх | Г,Ш |
| | Төрийн албан хаагчийн ёсзүй, үйлчилгээний стандартыг мөрдөн ажиллах | Гүйцэтгэл хувиар | Г |

## 2. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

| | |
|---|---|
| **Боловсрол** | Бакалавр болон дипломын боловсролтой байх. |
| **Мэргэжил** | Ус судлал D,C 0669<br>Цаг уурын инженер D0666<br>Цаг уур мэдээлэл, прогноз C,D 0665 |
| **Мэргэшил** | Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагаа гардан гүйцэтгэх эрх авсан байх<br>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр мэргэшсэн байх |
| **Туршлага** | Цаг уур, ус судлал, урьдчилан мэдээлэх инженерээр 3-аас доошгүй жил ажиллаж байсан. |
| **Ур чадвар** | • Багаар ажиллах<br>• Харилцааны соёл<br>• Бусдыг манлайлах<br>• ArcGIS болон хэрэглээний программ дээр ажиллах чадвар<br>• Англи болон бусад хэлээр унших, сонсож ойлгодог,<br>• Бичиг хэргийн програм, интернет, сүлжээний орчинд ажиллах<br>• Цахилгаан, техникийн анхан шатны засвар үйлчилгээг хийдэг байх |

## 3. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

| | |
|---|---|
| **Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:** УЦУОШТөвийн дарга | |
| **Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:**<br><br>- ЦАЗНЭ-ийн техникч, жолооч -1<br>- ЦАЗНЭ-ийн томилгоот албан хаагчид<br><br>Нийт: 11 | **Бусад харилцах субъект:**<br>*Байгууллагын дотор*<br>• Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга<br>• ЦУОТХ-ийн дарга<br>• Ерөнхий нягтлан бодогч<br>• Улсын сүлжээний салбарууд<br>*Шууд харилцах байгууллага*<br>• *ЦУОШГазар*<br>*Шууд бус харилцах байгууллага*<br>• Аймаг, сумын ЗДТГ<br>• БОАЖГазар<br>• Онцгой байдлын газар<br>• Хэвлэл мэдээллийн байгууллага |

## 4. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| **Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:** | **Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:** |
| --- | --- |
| **Албан тушаалын нэр:**<br><br>Албан тушаал: Хүний нөөцийн ажилтан<br>……………………… С. Баясгалан<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br><br>2025 оны 8 дугаар сарын 13-ны өдөр | Байгууллагын нэр: УЦУОШ төв<br><br>Шийдвэрийн огноо: 2025.08.13<br><br>Дугаар: Б/44 |

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр: ХЭНТИЙ АЙМГИЙН УЦУОШТ

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/тэмдэг)

……………… Б.ХЭРЛЭНЧИМЭГ

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2025 оны 8 дугаар сарын 13-ны өдөр

Танилцсан………………………………